



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хөдөө аж ахуйн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/013/НА-СТА-ОНТС

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203

Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207

Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207

Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК

Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг

Утас: 88883776

Цахим хаяг: [khaanconsultingaudit@gmail.com](mailto:khaanconsultingaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 257  
танай 2025.01.24 -ны № 56 -т

ДОРНОД АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ  
АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.МӨНХБАЯР ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөдөө аж ахуйн сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дорнод аймгийн ИТХ-ын 2021 оны 5/08 дугаар тогтоол, ЗД-ын 2021 оны А/121 дүгээр захирамжаар Хөдөө аж ахуйг дэмжих сан байгуулсан ба Засгийн газрын тусгай сангийн хуулийн өөрчлөлтөөр үйл ажиллагааг татан буулгаагүй байгаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.19-д "Хөдөө аж ахуйг дэмжих сан" гэж заасан байсныг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байна. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Тусгай санг хуулиар байгуулж, татан буулгана" гэж заасанг зөрчсөн, толилуулах ба нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022147

### **Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Хөдөө аж ахуйн сан нь 2024 онд хэрэгжүүлэх 2 төсөл, 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 19 дүгээр хуралдаанаар баталсан бөгөөд төслийг дүгнээгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>389,853,766.00</u>	<u>179,530,149.71</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	281,344,438.29	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	281,344,438.29	-
3121	Төгрөг	281,344,438.29	-
31211	Төрийн сангийн харилцах	281,344,438.29	
33	АВЛАГА	38,589,327.71	117,530,149.71
335	Бусад авлага	-	80,455,889.00
3351	Байгууллагаас авах авлага		80,455,889.00
336	Зээлийн авлага	38,589,327.71	37,074,260.71
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	38,589,327.71	37,074,260.71
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	38,589,327.71	37,074,260.71
35	БАРАА МАТЕРИАЛ	69,920,000.00	62,000,000.00
354	Хангамжийн материал	69,920,000.00	62,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	69,920,000.00	62,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>389,853,766.00</u>	<u>179,530,149.71</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>389,853,766.00</u>	<u>179,530,149.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	389,853,766.00	179,530,149.71
512	Хуримтлагдсан үр дүн	389,853,766.00	179,530,149.71
51210	Өмнөх үеийн үр дүн	389,853,566.00	389,853,766.00
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	(210,323,616.29)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>389,853,766.00</u>	<u>179,530,149.71</u>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан/төгрөгөөр/

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	870,848,200.00	1,347,748,255.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,957,900.00	586,748,255.00
120	Нийтлэг татварын бус орлого	89,957,900.00	586,748,255.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	89,957,900.00	586,748,255.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	89,957,900.00	586,748,255.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	780,890,300.00	761,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	780,890,300.00	761,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	779,890,300.00	761,000,000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	1,000,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	684,820,000.00	1,101,991,871.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684,820,000.00	1,101,991,871.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	683,820,000.00	595,079,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,500,000.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	3,500,000.00	

**Дорнод аймгийн Хөдөө аж ахуйн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	680,320,000.00	595,079,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	680,320,000.00	595,079,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	506,912,671.29
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,000,000.00	506,912,671.29
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,000,000.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		506,912,671.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>186,028,200.00</u>	<u>245,756,383.71</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	56,452,000.00	456,080,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	56,452,000.00	456,080,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(56,452,000.00)	(456,080,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>129,576,200.00</u>	<u>(210,323,616.29)</u>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(1)	<u>881,449,200.00</u>	<u>1,268,807,433.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,558,900.00	507,807,433.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,558,900.00	507,807,433.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,558,900.00	507,807,433.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,558,900.00	507,807,433.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	780,890,300.00	761,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	780,890,300.00	761,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	779,890,300.00	761,000,000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	1,000,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>754,740,000.00</u>	<u>1,550,151,871.29</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	754,740,000.00	1,550,151,871.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	754,740,000.00	1,043,239,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,500,000.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	3,500,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	751,240,000.00	1,043,239,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	751,240,000.00	1,043,239,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	506,912,671.29
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	506,912,671.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		506,912,671.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>126,709,200.00</u>	<u>(281,344,438.29)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	126,709,200.00	(281,344,438.29)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	154,635,238.29	281,344,438.29
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	281,344,438.29	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	260,277,566.00	260,277,566.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	260,277,566.00	260,277,566.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	129,576,200.00	129,576,200.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	389,853,766.00	389,853,766.00
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	389,853,766.00	389,853,766.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	389,853,766.00	389,853,766.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	-210,323,616.29	-210,323,616.29
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	179,530,149.71	179,530,149.71

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,100,910,900.0	1,043,239,200.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,100,910,900.0	1,043,239,200.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,100,910,900.0	1,043,239,200.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,910,900.0	1,043,239,200.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,910,900.0	1,043,239,200.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	761,000,000.0	1,268,807,433.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	761,000,000.0	761,000,000.0
122005	Орон нутгийн төсвөөс	761,000,000.0	761,000,000.0
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	507,807,433.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		507,807,433.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	281,344,438.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,253.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлж нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

- Өмнөх онуудын хуримтлагдсан авлагын 17,253,2 мянган төгрөгийн бүртгэл, тайланд тусгуулсан.

Аудитаар 17,253.2 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

### 2.1 Албан шаардлага

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.19-д “Хөдөө аж ахуйг дэмжих сан” гэж заасан байсныг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байна. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Тусгай санг хуулиар байгуулж, татан буулгана” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### 2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Өмнөх онуудын 17.3 сая төгрөгийн хуримтлагдсан авлагыг бүртгэл тайланд тусгаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Авлагыг үнэн зөв бүртгэж байх зөвлөмж өгөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх онуудын хуримтлагдсан авлагыг НББ д бүртгээгүй	1	17,253,2					1	17,253,2				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>17,253,2</b>					<b>1</b>	<b>17,253,2</b>				

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх онуудын хуримтлагдсан авлагыг НББ д бүртгээгүй	1	17,253,2					1	17,253,2				
ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй	1				1	-						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>17,253,2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>17,253,2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 26/19125/99  
АА-2025/0131 НА-СТА-ТМЗ

Чойбалсан хот

Г Зөрчил арилгах тухай Г


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймгийн ЗД-ын 2021 оны А/121 дүгээр захирамж, ИТХ-ын 2021 оны 5/08 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйг дэмжих сан байгуулсан ба Засгийн газрын тусгай сангийн хуулийн өөрчлөлтөөр үйл ажиллагааг татан буулгаагүй байгаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.19-д “Хөдөө аж ахуйг дэмжих сан” гэж заасан байсныг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байна. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Тусгай санг хуулиар байгуулж, татан буулгана” гэж заасанг зөрчсөн, толилуулах ба нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн  
**ШААРДАХ нь:**

1. Хуулийн өөрчлөлтийг дагаж мөрдөөгүй, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Хууль эрх зүйн шийдвэрийг баримтлан ажиллахыг Хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбаяр, нягтлан бодогч Б.Золзаяад даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ

2125040262